

ОЛОН УЛСЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ГАДААД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ба МОНГОЛ УЛС

Д.Тунгалаг¹

Хорин нэгдүгээр зууны эхний үеийн дэлхийн хөгжлийг дагаад хүн амын, ялангуяа хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн хүчтэй явагдах боллоо. Олон улсын ажиллах хүчний шилжих хөдөлгөөн нь олон улсын эдийн засгийн харилцааны чухал хэсэг болж дэлхий нийтээр шилжих хөдөлгөөнд оролцож байгаа хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоо сүүлийн 5 жилд 10 гаруй дахин өссөн гэсэн судалгааг Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагаас гаргасан байна.

Хорьдугаар зууны сүүлийн хагас, хорин нэгдүгээр зууны эхэн үеийн олон улсын ажиллах хүчний шилжих хөдөлгөөний урсгал, чиг хандлагын талаар өмнөх өгүүлэлдээ бичсэн билээ. Харин энэхүү өгүүлэлдээ Монгол улсын ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний талаар төр засгаас явуулж буй бодлого, гадаадад хөдөлмөр эрхэлж буй монгол иргэдийн байдал, цаашдын чиг хандлага, сүүлийн жилүүдэд гарсан өөрчлөлт, тулгамдаж буй асуудал, түүнийг давах арга замын талаар, мөн түүнчлэн Монгол улсад ажиллаж амьдарч буй гадаадын иргэдийн талаар өгүүлэхийг зорьлоо.

Гадаад шилжих хөдөлгөөнийг хөдөлмөрийн, гэр бүлийн, аялал жуулчлалын гэж хуваахаас гадна олон улсын ажиллах хүчний зах зээл үндэсний хил хязгаарыг давсан олон төрлийн чиглэлтэй хөдөлмөрийн нөөцийн урсгалыг бий болгох, бараа үйлчилгээ, капитал, мэдээллийн зах зээлтэй зэрэгцэн орших байдлаар илэрч байна.

Манай улсын хувьд гадагшаа шилжих нүүдэл залуучуудын дунд элбэг байгаа нь тэдний сурч өндөр боловсрол эзэмших, дотооддоо хөдөлмөр эрхлэх тал дээр төр, засгийн бодлого хангалттай сайн биш байгаатай шууд холбоотой юм. Тийм учраас залуучууд аль нэг гадаад оронд очиж боловсрол эзэмшин сургуулиа төгсөөд тэндээ үлдэж ажиллаж амьдрах нь элбэг байгаа нь нууцгүй. Манай улсын эдийн засаг харьцангуй тогтворжиж байгаа ч хүн амын орлого бодитой нэмэгдэхгүй байгаа нь залуу, дунд үеийнхнийг хүнд хэцүү боловч цалин хөлс өндөртэй хөдөлмөрийн зах зээлийг сонгоход хүргэж байна.

¹ МУИС-ийн багш, доктор (Ph.D), профессор

Хүн амын гадаад шилжих хөдөлгөөний нэг томоохон хэсгийг хөдөлмөр эрхлэх зорилгоор хилийн чанадад шилжин суурьшиж амьдрах асуудал эзэлдэг. Манай улсын нэлээд олон иргэд албан ёсоор буюу “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн дагуу гадаадад гэрээгээр хөдөлмөр эрхэлж байна. Харин үүний зэрэгцээгээр хараар ажиллаж амьдрах буюу хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон боловч тухайн хүлээн авагч улсад үргэлжлүүлэн ажиллаж амьдарч байгаа олон тооны иргэд байна.

Гадаадад гарч ажил хөдөлмөр эрхлэх асуудал нь нэг талаараа олон улсын эдийн засгийн харилцаа эрчимтэй хөгжих болсон өнөөгийн онцлогтой шууд холбоотой ч нөгөө талаараа улс орнуудын улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, хүмүүсийн боловсрол эзэмших гэсэн эрмэлзэл, өндөр технологийн үр дүнтэй шууд холбоотой гэж хэлж болно. Тухайлбал, манай улсад ажлын байр хомс, орлого бага байдгаас гадаадад ажиллах хүчээ алдах нэг шалтгаан болж байгаа нь тодорхой билээ.

1990 онд Монгол улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж Үндсэн хуулиараа иргэдийнхээ эрхийг, түүний дотор хөдөлмөрлөх, мөн ажил хөдөлмөрөө сонгох эрхийг нь баталгаажуулснаас хойш даруй хорь гаруй жил өнгөрөөд байна. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед үндэсний үйлдвэрүүд үүдээ хааж, улмаар ажилгүйдэл газар авч хөдөлмөрийн хөлсний үнэлэмж буурч, төрөөс хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах, ажиллах хүчний өртгийг тодорхойлох боломжгүй болсон зэрэг нь иргэдийг аль болох илүү цалин хөлстэй ажлын байр, ая тухтай амьдрах боломжийг эрж хайх байдал руу хөтөлсөн билээ. Иймээс ч сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу шилжих дотоодын шилжих хөдөлгөөн, гадаадад гарч хөдөлмөр эрхлэх зорилго бүхий гадаад шилжих хөдөлгөөний аль аль нь нэлээд нэмэгдсэн юм.

Монголчууд ОХУ, БНХАУ руу ганзагын наймаа хийхээр богино хугацаагаар олноор явж эхэлснээр Монгол улсын гадаад руу чиглэсэн шилжих хөдөлгөөний эх суурь тавигдсан гэж үздэг. Ингэснээр манай улсын иргэд бусад олон улс руу урт болон богино хугацаагаар явах боломж улам нээлттэй болж ирсэн. Зах зээлд шилжиж байсан тэр үед үндэсний үйлдвэрүүд үүдээ хааж олон мянган иргэд ажилгүй болж өрх гэрээ тэжээх аргагүйд хүрч байсан нь маргашгүй үнэн билээ. Мөн соёл урлагийн байгууллагууд ажиллахаа больж олон арван уран бүтээлчид, жүжигчид ажилгүй болсон ба тэдний зарим

хэсэг нь, тухайлбал, ардын дуу бүжгийн чуулгын бүжигчид, циркийн жүжигчид хэсэг хэсгээрээ гадаад аль нэгэн оронд очиж тоглолт хийн амиа зогоож эхэлснээр тэдний амьдралд өөрчлөлт орж тодорхой амжилтанд хүрч өнөөдөр гэхэд тэдний ихэнх нь аль нэг гадаад оронд хөдөлмөр эрхлэн ажиллаж амьдарч байгаа жишээ олон байна.

Мөн олон мянган охид хөвгүүд гадаад хэл сурах, мэргэжил эзэмших зорилгоор анх гадаадад гарч, улмаар сургуулиа төгсөөд тэндээ үргэлжлүүлэн ажил хөдөлмөр эрхэлж сайн сайхан амьдарч байгаа иргэд ч олон бий. Харин сүүлийн жилүүдэд манай улсад уул уурхайн салбар хөгжиж ажлын байр олноор бий болж ажиллах хүч шаардлагатай болсноор тэдний ихэнх хэсэг нь эх орондоо эргэн ирж ажил хөдөлмөр эрхлэх боллоо. Энэ нь Монгол улсын Ерөнхий сайдын санаачлагаар 2010 онд батлагдсан “Зөгийн үүр” хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотой юм. Гэвч өнөөдрийн байдлаар гадаадад сурч мэргэжил боловсрол эзэмшин ажил хөдөлмөр эрхэлж буй бүх залуучуудаа бүгдийг нь авчирч ажлын байраар ханган эх орныхоо бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулах боломж бүрэн хангагдаагүй байна.

Ази тивийн Энэтхэг, Пакистан, Филиппин, БНСУ, Тайланд зэрэг зарим орнууд ажиллах хүчний талаар явуулж буй бодлогынхоо хүрээнд тодорхой хөтөлбөр боловсруулан хилийн чанадад ажиллаж байгаа иргэдээ хамгаалахад чиглэсэн тусгайлсан арга хэмжээг анх авч хэрэгжүүлсэн орнууд юм.

Харин манай улсад Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам ажиллах хүч гадаадад гаргах бодлого зохицуулалтыг хангаж байна. Өнөөдрийн байдлаар 14 аж ахуйн нэгж, байгууллага гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөлтэй ажиллаж манай улсаас албан ёсны гэрээгээр ажиллах хүч гаргаж байна.

2010 оны байдлаар гадаадад 6 сараас дээш хугацаагаар амьдарч байгаа Монгол улсын харьяат нийт иргэд 107140²¹ байна гэсэн тооцоо гарчээ. Хилийн чанадад байгаа нийт монголчуудын тоо 110 орчим мянга болж 20 гаруй улсад сурч, ажиллаж амьдарч байна гэсэн статистик судалгаа ч бий. Эдгээрийн дийлэнх хувийг БНСУ, АНУ, БНЧУ, Герман, Их Британи, Япон улсад ажиллаж, амьдарч буй иргэд эзэлдэг. БНСУ-д ажиллах хүч гаргах үйл ажиллагаа 1997 оноос эхэлсэн бөгөөд үүнээс хойш 17 жилийн хугацаанд шилжих тоогоор 24 орчим мянган иргэнийг тухайн улсад хөдөлмөрийн гэрээгээр илгээсэн байна.

²¹ Монгол улсын “Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллого”

Хууль бусаар гадаадад ажиллаж амьдарч байгаа монгол иргэдийн тоо 30 мянга хол давжээ. Зарим нэгэн жишээ дурдвал: БНЧУ-д 5 мянган монголчууд голдуу оёдол, машин, цахилгаан хэрэгсэл, хүнсний үйлдвэрт өдөрт 8-16 цаг ажилладаг ба сарын цалин ойролцоогоор 700 ам.доллар байдаг байна. Харин БНСУ-д ажиллаж амьдарч байгаа бүртгэлтэй иргэдийн тоо 30 гаруй мянга, үүнээс хөдөлмөрийн гэрээгээр 17 мянга орчим хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 90 гаруй хувь нь жижиг, дунд үйлдвэрт ажилладаг. Тэдний сарын дундаж цалин 500-1500 ам.доллар. Гэхдээ хамгийн хүнд хүчир, бохир, аюултай ажлыг хийдэг ажээ.

Өнөөдөр Монгол улсад ажилгүйчүүдийн тоо 90 орчим мянга ажилгүйдлийн түвшин 7,6 хувьтай³ байгаа билээ. Гэтэл гадаадад ажиллаж амьдарч байгаа 100 гаруй мянган иргэдээ нэмээд үзэхээр нийт хүн амын 15 орчим хувийг эзэлж байна. Энэ нь манай улсад дор хаяж 200 мянган ажлын байр шинээр шаардлагатай байна гэсэн үг юм. Гэтэл НХХЯ-аас 2013 оны байдлаар ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалга 219013, үүнээс ажилд зуучлан оруулсан хүний тоо 65645 байна гэсэн судалгаа⁴ гаргажээ. Үүнээс харахад ажиллах хүчний эрэлт нийлүүлэлт хэт их зөрүүтэй байгаа нь ажиглагдаж байна. Иймд ажлын байрны эрэлтийг үндэслэн сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх замаар тухайн ажлын байранд шаардлагатай мэргэжилтэн бэлдэхэд авч буй арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм.

Хилийн чанад руу гарах гол шалтгаан нь сурах, ажиллах, аялах зорилгоор явдаг нь дэлхий нийтийн жишиг билээ. Манай улсын иргэдийн хувьд ч мөн адил. Хамгийн гол нь тэднийг аль нэг гадаад оронд өндөр мэргэжил боловсрол эзэмшээд тодорхой хэмжээний туршлагатай болчихоод эх орондоо эргээд ирэхэд нь ажлын байраар хангаж амьдрал ахуйг нь дэмждэг байх нөхцлийг бүрдүүлэх нь л манай төр засгийн гол анхаарвал зохих асуудлын нэг болов уу.

Тийм ч учраас хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн хувьд төр засгаас тэдэнд чиглэсэн тодорхой бодлого боловсруулан гадаадад хөдөлмөр эрхлэх асуудлыг тодорхой хэмжээгээр зохицуулж олон янзын арга хэмжээ авч байгаа ч иргэд үйлдвэрлэлийн ба ахуйн осолд өртөж гэмтэж бэртэх, ажлаас халагдах, улмаар хууль бусаар гадаад улсад ажиллаж амьдрах явдал түгээмэл гарч хууль бусаар гадаад улсад ажиллаж амьдарч янз бүрийн зөрчилд

3 Ажиллах хүчний 2013 оны 3-р улирлын тайлан

4 Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээ, УБ, 2013

холбогдох, хөдөлмөрийн мөлжлөгийн зэрэг эрсдэлд орох хандлага илэрсээр байгаа нь нууц биш билээ. Иймд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, зуучлагч байгууллага, Элчин сайдын яамдын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, идэвхжүүлэх замаар хилийн чанадад гэрээгээр ажиллаж байгаа иргэдийнхээ хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангах, хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдээ эх орондоо буцаж ирж, эзэмшсэн мэргэжил, ур чадвараар ажил хөдөлмөр эрхлэхийг дэмжих, хилийн чанадад хууль бусаар ажиллаж амьдарч байгаа иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар гадаад орнууд дахь Дипломат төлөөлөгчийн газар, ТББ-уудтай хамтран хамгаалах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

Мөн сүүлийн жилүүдэд төр засгаас гадаадаас ажиллах хүч авч, гадаад руу ажиллах хүч илгээж байгаа өнөөгийн үйл ажиллагааны хүрээнд хуримтлуулсан туршлага, сургамжид тулгуурлан боловсронгуй болгох зорилт тавин “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн шинэчилсэн найруулга болох Монгол улсын иргэн гадаадад, гадаадын иргэн Монгол улсад хөдөлмөр эрхлэх тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. Тухайлбал, төрийн болон холбогдох бусад байгууллагын чиг үүргүүд, гадаадад хөдөлмөр эрхлэхээр зуучлах үйлчилгээ, зохицуулалт сайжруулах, тэдний үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, түүнчлэн ажиллах хүч авч байгаа өнөөгийн зохицуулалтыг ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж, тухайлбал дотоодоос хангах боломжгүй байгаа ажил мэргэжлийн хэрэгцээг аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд үндэслэн бодитойгоор тогтоох, ажлын байрны төлбөрийг тухайн ажил мэргэжлийн дотоод дахь олдоц, бэлтгэгдсэн байдал зэргээс хамааруулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан жил бүр уян хатан тогтоох зэрэг чиглэл баримталж байна.

БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамтай байгуулсан гэрээний дагуу манай иргэд хамгийн олноор ажиллаж байгаа тус улсад төрийн үйлчилгээг сайжруулах зорилгоор “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг Сөүл хотод байгуулснаар иргэддээ хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эмэгтэйчүүд, хүний эрхийн асуудлаар үйлчилгээ үзүүлэх, мөн мэргэжлийн ур чадварын түр сургалтын үйлчилгээний хүртээмжийг бий болгох арга хэмжээг авсан байна. Мөн хоёр орны

Засгийн газрын хооронд 2007 онд байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай” хэлэлцээрийн дагуу БНСУ-д гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг Монгол улсын тэтгэврийн даатгалд хамруулах, хэлэлцээр хийгдэхээс өмнө тус улсын тэтгэврийн даатгалд даатгуулж байсан иргэдийн төлсөн шимтгэлийн мөнгийг буцаан олгох зэрэг үйл ажиллагааг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөгчийн албаар дамжуулан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн иргэдийг харилцан хөдөлмөр эрхлүүлэх тухай засгийн газар хоорондын хэлэлцээрийг ОХУ-тай, Нийгмийн хамгааллын хэлэлцээрийг БНЧУ, БНУУ-тай байгуулахаар тохиролцоонд хүрээд байна. Хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдээ эх орондоо буцаж ирж, эзэмшсэн мэргэжил, ур чадвараар ажил хөдөлмөр эрхлэхийг дэмжих зорилгоор юуны түрүүнд тэднийг Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн, түүний дотор одоогоор хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд дэх сул чөлөөтэй ажлын байр, бизнес эрхлэх боломж зэрэг цогц мэдээлэл, үйлчилгээгээр хангах www.labornet.mn вэб хуудас ажиллуулж байна.

Мөн Монгол улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг таниулах, мэдээллээр газар дээр нь хангах арга хэмжээг АНУ, ХБНГУ, БНЧУ, Дани, БНСУ зэрэг орнуудад авч хэрэгжүүлсэн байна. Европын холбооны орнууд, тухайлбал БНЧУ, БНПУ, БНУУ, Швед, БНТУ, АНУ, БНСУ болон бусад улсуудад хууль бусаар ажиллаж амьдарч байгаа монгол иргэд, түүний дотор хөдөлмөрийн мөлжлөг зэрэг эрсдэлд өртөж болзошгүй байдалд байгаа иргэдээ эх орондоо тодорхой нөхцөл, бодлого, хууль эрх зүй болон эдийн засгийн дэмжлэгтэйгээр сайн дурын үндсэн дээр буцаах зорилготой эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг өргөжүүлэх зорилгоор Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагад хүсэлт тавьсныг тус байгууллага дэмжсэний үр дүнд уг хөтөлбөрийг ихэвчлэн ТББ-ын санаачлагад тулгуурлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, БНТУ-д хууль бусаар амьдарч байсан 150 иргэнийг “Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын шугамаар оруулж эх оронд нь авчирч, хөдөлмөр эрхлэх орлогыг мөн олгуулжээ.

Дээр дурдсан Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага нь анх 1951 онд байгуулагдсан, эдүгээ 132 орныг эгнээндээ нэгтгэсэн, нийт 400 гаруй салбар нэгжтэй, улс хооронд шилжилт хөдөлгөөнийг зохицуулдаг засгийн газар хоорондын байгууллага юм. Тодруулбал, цагаачлал, шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй нийгэм, эдийн засгийн бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх, үндэсний

чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэлхийн хэмжээнд явуулдаг. Манай улс энэ байгууллагын гишүүнээр 2008 онд элссэн бөгөөд өнгөрсөн хугацаанд 5 мянга гаруй монгол иргэдийн асуудлыг шийдвэрлэж өгсөн байна.

Хууль бусаар амьдарч буй иргэдийнхээ асуудлыг зүй зохистой шийдэх, гадаад шилжих хөдөлгөөнтэй холбогдсон нөхцөл байдал, тулгарч буй сорилтуудыг даван туулахад төрийн ба төрийн бус байгууллага, иргэний нийгмийн хамтын хүчин чармайлт чухал ач холбогдолтой нь тодорхой. Тийм ч учраас НХХЯ-аас санаачлан холбогдох төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран хэд хэдэн арга хэмжээнүүдийг улсын хэмжээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тухайлбал, хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөний эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо зуучлалын үйлчилгээг сайжруулах, зуучлагч байгууллагад тавих шаардлагыг өндөржүүлэхэд анхаарах, хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдтэй холбогдсон бүртгэл мэдээллийг сайжруулах талаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөний зохицуулалтын асуудлаар хоёр талын гэрээ хэлэлцээр байгуулж ажиллах, энэ чиглэлээрх олон улсын гэрээ, конвенцийг судлах, тэдгээрт нийцсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зэрэг бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой ажлуудыг хийж байна.

Түүнчлэн НХХЯ-ны вэб хуудсанд тус яамнаас хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөний чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хилийн чанадад байгаа иргэдийн өргөдөл, асуултад хариулт, мэдээлэл, зөвлөгөө өгөх шууд харьцах булан ажиллуулах, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл, хууль бус зуучлал, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэргэшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, тэдэнтэй нягт хамтран ажиллах, хилийн чанадад ажиллаж амьдарч байгаа иргэдийнхээ хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хилийн чанад дахь болон дотоодын ТББ-уудтай холбоо тогтоох, зарим үйлчилгээг тэдгээр байгууллагаар гүйцэтгүүлэх, монголчууд олноор ажиллаж амьдарч байгаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газарт хөдөлмөрийн атташе ажиллуулах талаар ГХЯ-тай хамтран ажиллах, хөдөлмөрийн мөлжлөгийн эрсдэлд өртөж болзошгүй иргэдээ эх орондоо сайн дурын үндсэн дээр буцаан авчрах хөтөлбөрүүдийг өргөжүүлэх чиглэлээр Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх,

монголчууд олноор ажиллаж амьдарч байгаа БНСУ-д байгуулсан “нэг цэгийн үйлчилгээ”-ний үйл ажиллагааг эрчимжүүлэх, хилийн чанадад ажиллаж байгаа иргэдийнхээ нөхцөл байдалтай газар дээр нь танилцах зэрэг олон ажлыг эхлээд байна.

Хэдийгээр төр засгаас ийнхүү олон янзын арга хэмжээ авч хэрэгжүүлж эхэлсэн ч гадаадад хөдөлмөр эрхэлж буй ажилчдын тоо тэр бүр буурахгүй, тэдний ажиллаж амьдрах хууль эрх зүйн орчин бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

Монгол улсад гадаадын иргэд хөдөлмөр эрхэлж байгаа тухайд гэвэл 2013 оны байдлаар 101 орны 8863 гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийг улсаар авч үзвэл 32,1 хувь нь БНХАУ-ын иргэд, 24,0 хувь нь БНАСАУ-ын иргэд, 7,6 хувь нь ОХУ-ын иргэд, 6,2 хувь нь БНСУ-ын иргэд, 6,2 хувь нь БНСВУ-ын иргэд, 4,0 хувь нь АНУ-ын иргэд, 3,2 хувь нь Австрали улсын иргэд, 1,7 хувь нь Филиппин улсын иргэд, 1,4 хувь нь Англи улсын иргэд, 1,4 хувь нь БНЭУ-ын иргэд, 1,1 хувь нь Казакстан улсын иргэд, 1,0 хувь нь Канад улсын иргэд, 0,5 хувь нь ӨАБНУ-ын иргэд, үлдэх хувийг бусад улсын иргэд эзэлж байна. Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл барилгын салбарт 26,3 хувь, уул уурхайн салбарт 16,3 хувь, худалдаа үйлчилгээний салбарт 13,3 хувь, боловсруулах үйлдвэрт 11,2 хувь, боловсролын салбарт 11,0 хувь, тээврийн салбарт 9,1 хувь, үлдсэн хувь нь бусад салбарт ногдож байна.

Улс орны эдийн засаг сайжирч хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр ажлын байр бий болж гадаад орнуудын мэргэжилтэн, ажилтнуудын ур чадварыг ашиглахын тулд гадаад иргэдийг олноор оруулан ирж хөдөлмөр эрхлүүлэх боллоо. Тухайлбал манай улс хямд ажиллах хүчийг БНХАУ-аас олноор оруулж ирж барилга, уул уурхай, нийтийн хоол болон газар тариалангийн салбарт ажиллуулж байна. Энэ нь хэдийгээр хоёр орны хооронд хийгдсэн ажиллах хүч авч ажиллуулах хэлэлцээрийн дагуу байдаг хэдий ч цөөн хүн амтай, том газар нутагтай манай орны хувьд үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, хөгжингүй, их хүн амтай Хятадад уусах магадлалтай байж болзошгүйг анхаарах хэрэгтэй юм.

Хөдөлмөрийн хүчийг гадаадаас шилжүүлэн авах нь ур чадварын хомсдолыг нөхөх сайн талтай боловч хөдөлмөрийн талаар төр засгаас явуулж буй бодлогын нэг чухал хэсэг нь эхлээд дотоодынхоо ажиллах хүчийг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой болов уу. Өөрөөр хэлбэл ажилгүй яваа монгол иргэддээ гадаадын ажилтнуудын тэрхүү

ур чадварыг юуны өмнө эзэмшүүлэх арга хэмжээ авах, улмаар ажлын байраар хангаж тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг хангахад анхаарах нь зүйтэй.

Манай орны хувьд “хүн амын цонх”-ны үе давхцаж байгаа өнөөгийн онцлогийг харгалзан хөдөлмөр эрхлэх чадвартай бүх иргэдээ ажилтай болгосноор хүн амын амьжиргааны түвшин дээшилж улмаар эдийн засгаа өсгөж болох давтагдашгүй боломж тохиож байгааг мартаж болохгүй юм.

Манай улс БНСУ, БНАСАУ, ОХУ, БНЧУ, АНЭУ, Тайвань улстай ажиллах хүч солилцох гэрээ байгуулсан бөгөөд Япон, БНХАУ-тай гэрээ байгуулахаар засгийн газрын түвшинд хэлэлцээр хийж байна. Өнөөгийн байдлаар Монгол улс БНСУ руу ажиллах хүч, Япон улс руу ур чадварын дадлагажигч илгээдэг бол БНАСАУ, БНХАУ-аас ажиллах хүч авдаг байна.

ОХУ, БНЧУ, АНЭУ, Тайвань зэрэг улстай хөдөлмөрийн хамтын ажиллагааны гэрээ байгуулсан боловч үйл ажиллагаа одоогоор идэвхгүй байна. Энэ нь ажлын байрны эрэлт нийлүүлэлт зөрж байгаатай холбоотой. Иймд хөдөлмөрийн хамтын гэрээ байгуулахдаа хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг судалж задлан шинжилсний үндсэн дээр гаднаас авч ирэх ажилчдын тоон болон чанарын харьцааг гаргах шаардлагатай юм.

Ингэхээр хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг зохицуулдаг хувийн болон төрийн бус байгууллагыг олноор байгуулж зөв ур чадварыг хэрэгцээтэй газарт байршуулах нь хамгийн зөв шийдэл. Иймд ажиллах хүчний шилжих хөдөлгөөнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүтээлч ур чадварыг үнэлэх системтэй уялдуулах хэрэгтэй.

Хамгийн түрүүнд одоо байгаа ажлын байраа хамгаалж үлдэх нь юу юунаас илүү чухал юм. Үүний тулд ажил олгогч эздийг урамшуулах арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн зарим судлаачдын үзэл бодолтой санал нийлж байгаа ч хамгийн гол нь манай орны хувьд бий болоод байгаа нэг онцлог, тухайлбал дотоодын ажилгүйчүүдийн тоотой дүйцэх хэмжээний гадаадын ажиллагсад манай оронд ажиллаж амьдарч байгаа нь юунаас ч илүү сонирхол татаж байгаа юм.

Монгол улсын засгийн газрын боловсруулсан төлөвлөгөөнд үйлдвэрлэлийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд 100 тэрбум төгрөг зарцуулахаар тусгасан нь ажилгүйдлийг бууруулах арга хэмжээний эхлэл болох нь дамжиггүй.

Аливаа орны хөгжил дэвшил иргэн бүр ажилтай байхаас шууд

шалтгаалдаг. Иймээс хамгийн эрэлт хэрэгцээтэй барилга, зам гүүрийн салбарт хөрөнгө оруулалт хийн ажлын байр бий болгох явдал чухал байна.

Эцэст нь гадаадад хөдөлмөр эрхэлж буй монгол иргэдийн хөдөлмөрийн хөлс тухайн улсын иргэдийн хөдөлмөрийн хөлснөөс маш доогуур, харин манай улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн хөдөлмөрийн хөлс монгол иргэдийнхээс хамаагүй өндөр байдаг буруу тогтолцоог халах зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэх цаг болжээ.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний талаар баримтлах бодлого” УБ, 2013 он
2. Ажиллах хүчний 2013 оны 3 дугаар улирлын судалгаа”-ны тайлан
3. ХЭҮТ-өөс гаргасан эмхэтгэл, УБ, 2013
4. Ажилд зуучлах үйлчилгээний мэдээллийн эмхэтгэл, УБ, 2013
5. Монгол улсын Үндсэн хууль
6. Хөдөлмөрийн тухай хууль
7. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
8. Нийгмийн даатгалын тухай хууль
9. Хөдөлмөр эрхлэлт үйлчилгээний төвийн судалгааны албаны тайлан, УБ, 2013
10. “Шилжин суурьшигчдад зориулсан гарын авлага”, УБ, 2012
11. “Дунд ба урт хугацаанн хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтийн таамаглал”, УБ, 2013
12. “Ажилд зуучлах үйлчилгээний мэдээллийн эмхэтгэл”, Монгол улсын Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр судалгааны институт, УБ, 2013
13. “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” Монгол улсын Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр судалгааны институт, УБ, 2013
14. “Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал-2013”, Хөдөлмөр эрхлэлт үйлчилгээний төв, УБ, 2014
15. “Бүгд Найрамдах Солонгос улсад ажиллаж буй монгол иргэдийн зарим эрхийн хэрэгжилт”, судалгааны тайлан, УБ, 2007
16. “Барометрийн судалгаа”, Хөдөлмөрийн яам, УБ, 2013
17. “Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээллийн гарын авлага”, УБ, 2013
18. “Гадаадын ажилчны хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль”, УБ, 2014
19. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн эмхэтгэл”, Хөдөлмөрийн яам, УБ, 2013